



СЭЛЭНГЭ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/38

Цагаантолгой

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, Амьтан ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг Улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, 24 дүгээр зүйлийн 24.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2, 31.6.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улаанбаатар хотын Малын удмын сангийн үндэсний төв Оросын холбооны улсын Буриад улсын "Улаан" ХХК-тай гэрээ байгуулж гэрээний дагуу Алтанбулаг боомтоор оруулж ирэх "Эделвай" 62 толгой эм хонийг Сант сумын Ивэн багийн нутаг дэвсгэрт байрлах Сант-Агро ХХК-ны фермд 14 хоногийн хугацаатай хорио цээрийн хяналтанд оруулахыг Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч (Г.Анхбаяр)-д үүрэг болгосугай.

2.Малын удмын сангийн үндэсний төвийн Алтанбулаг боомтоор оруулж ирэх "Эделвай" үүлдрийн 62 толгой эм хонийг аймгийн магадлан итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулж, эрүүл мэндийн үзлэг халдваргүйтгэлийг холбогдох заавар, журмын дагуу хийж гүйцэтгэхийг "Бошгын булаг" ХХК-ны малын эмч (Ө.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

3.Мэргэжлийн байгууллагаас өгсөн заавар зөвлөмжийн дагуу хорио цээрийн дэглэмийг баримталж ажиллахыг Малын удмын сангийн үндэсний төвд үүрэг болгосугай.



С.ШИЖИРБААТАР

Боловсруулсан: *О. Винобаев*
Хянасан: *Ч. Азизов*
Хувь: *1*